

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийг баталсан.

Тус хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

- Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ
- Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ
- Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээ


1.1. АЖЛЫН БАЙРНЫ ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын 2017 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн А/27 тоот тушаалаар ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх, ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсэг нь хөтөлбөрийг зохион байгуулах удирдамж батлуулж, удирдамжийн дагуу ажиллалаа.

7 дугаар сарын 21-нээс 8 дугаар сарын 25-ны өдрүүдэд Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан 120 иргэний хүсэлт, баримт бичгийн бүрдүүлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа ажлын байртай танилцсан.

Иргэдийн үйлдвэрлэл эрхэлж буй ажлын байрны зураг.



Тус арга хэмжээний шаардлага хангасан 104 иргэнд 6,7,8,9,10 дугаар сарын ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт **58,436,000** төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан. Арга хэмжээнд хамрагдсан иргэдийг дүүргээр нь авч үзвэл:

№	Дүүрэг	Хамрагдсан иргэдийн тоо
1	Сонгино хайрхан	28
2	Чингэлтэй	21
3	Баянгол	12
4	Хан-уул	13
5	Сүхбаатар	8
6	Баянзүрх	14
7	Багануур	5
8	Налайх	3
Нийт дүн		104

1.2. АЖИЛ ОЛГОГЧИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/210 тоот албан бичгийг Нийслэлийн 9 Дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд хүргүүлсэн. Уг албан бичигт арга хэмжээний шаардлага хангасан ажил олгогчийн баримт бичгийг бүрдүүлэн ирүүлэх тухай тусгасан.

Тус арга хэмжээнд хамрагдах шаардлага хангасан аж ахуй нэгж байгууллага байхгүй гэж Сүхбаатар, Налайх, Багахангай, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргүүд албан бичгээр хариу өгсөн.

Мөн Багануур, Чингэлтэй дүүргийн ирүүлсэн баримт бичиг нь арга хэмжээний шаардлага хангаагүй тул хариуцсан мэргэжилтнүүдэд нь хариу өгөн ажиллалаа.

Арга хэмжээнд хамрагдах ажил олгогч байхгүй байсан тул Хөдөлмөр халамжийн, үйлчилгээний ерөнхий газарт албан тоот хүргүүлэн ажиллалаа.

1.3. АЖ АХУЙ ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын 2017 оны 06 сарын 14-ний өдрийн А/20 дугаар тушаалаар 1505 иргэнд 3 хоногоор зохион байгуулж суралцагчдын зардлыг 15000 төгрөгөөр тооцохоор шийдвэрлэсэн.

Мөн 2017 оны 07 сарын 21-ний өдрийн А/27 тоот тушаалаар Ажлын байртай танилцах ажлын хэсэг байгуулан ажилласан.

Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах хүсэлтээ ирүүлсэн Бизнес инкубатор төвүүд, Мэргэшсэн сургалтын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж эхний ээлжинд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Бизнес инкубатор төв, Монголын Хүний нөөцийн менежментийн холбоо, “Биродом” ХХК, “Ивээлт зөн”, “Ирмүүн төгс”, “Хөдөлмөр хамгаалал хүний хөгжлийн төв ТББ”, “Технож” Бизнес инкубатор төв зэрэг7 байгууллагатай 905 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг Аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулахаар тохиролцон гэрээ байгуулсан.

ХХҮЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу Аж ахуй эрхлэлтийн сургалт явуулах эрх авсан Монголын экспорт импортыг дэмжих үндэсний төв-“Star moon”, “Итгэлт бүтээмж”, Тайжийн удам”, ЖДҮНХ, Карьерийн эхлэл, “Жи эс эй эс”, Футур зэрэг мэргэшсэн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг судлан сургалтын хугацааг 3 хоногоор, оролцогчийн зардлыг 15000

төгрөгөөр тооцон доорхи хязгаарт багтаан сургалт явуулахаар тохиролцон гэрээ байгуулж ажиллалаа.

№	Мэргэшсэн сургалтын байгууллага, БИТ	Сургалтанд хамруулсан иргэний тоо	Олгосон санхүүжилт
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Бизнес инкубатор төв	285	4,275,000
2	Монголын Хүний нөөцийн менежментийн холбоо,	33	495,000
3	Ивээлт зөн	37	555,000
4	Ирмүүн төгс ХХК	87	1,305,000
5	“Хөдөлмөр хамгаалал хүний хөгжлийн төв ТББ”	0 /Сургалт явуулахгүй болсон/	0,0
6	Технож БИТ	37	555,000
7	“Биродом” ХХК	90 /тайлан хугацаа хоцорсон	/санхүүжилт олгогдоогүй/
8	Тайжийн удам ХХК-ний дэргэдэх Дэвжих ирээдүй БИТ	120	1,800,000
9	ЖДҮНХ	114	1,710,000
10	Итгэлт бүтээмж төв	270	4,050,000
11	Карьерийн эхлэл	86	1,290,000
12	Жи эс эй эс	35	525,000
13	“Стар мүүн” сургалтын төв	274	4,110,000
14	Футур сургалтын төв	40	600,000
Нийт дүн		1508	21,270,000

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу сургалтын үйл явцад хяналт үнэлгээ хийх ажлыг 85 удаа зохион байгуулж, Аж ахуй эрхлэлтийн сургалтанд оролцогчдод Хөдөлмөр эрхлэлтийн газрын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг тодорхойлох судалгаа авсан байна.

Дээрх мэргэшсэн сургалтын байгууллагууд 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 115 удаагийн сургалтаар 7 дүүргийн 1508 иргэнийг хамруулаад байна.

Сургалтанд хамрагдсан иргэдийн 970 нь эмэгтэй, 1403 нь хөгжлийн бэрхшээлтэй, 105 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагч байна. Тэдгээрийн сургалтын зардалд 12 Мэргэшсэн сургалтын байгууллагад 21,7 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоод байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг тодорхойлох судалгаанд 1255 иргэн хамрагдсанаас Аж ахуй эрхлэлтийн сургалтанд 784 иргэн буюу 62,5 хувь Аж ахуй эрхлэлтийн сургалтанд анх удаа хамрагдаж байна гэж хариулсан байна.



Итгэлт бүтээмж төв
/Баянзүрх дүүргийн 10-р хороо/



Тайжийн удам-Дэвжих ирээдүй БИТ
/Баянгол дүүргийн 3- хороо/



Стармүүн Сургалтын төв /Баянзүрх дүүрэг/

Сургалтын явцын хяналтаас дүгнэлт хийхэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн БИТ, “Итгэлт бүтээмж, “Стар мүүн” зэрэг сургалтын байгууллагууд хороодын Засаг дарга нар, дүүргийн ХБИХ-той нягт уялдаатай ажилласнаар ирц оролцоо сайтай үр дүнтэй сургалтыг зохион байгуулж байв.

Зарим сургалтын байгууллагуудын зохион байгуулсан сургалт ирц оролцоо, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамж дулимаг, багшийн ур чадвар сайнгүй байгаа нь ажиглагдаж байлаа.

Мэргэшсэн сургалтын байгууллагууд нь хугацаа богино, санхүүжилт бага, ажиллагаа ихтэй гэсэн шалтгаанаар гэрээнд заасан тоо хэмжээнд хүргэж сургалтаа зохион байгуулж чадахгүй байсан нь хүндрэл учруулж байсан.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний хүрээнд хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилт дүүргүүдэд тогтмол хэрэгжиж байдаг тул ажил олгогч гарт тавигдах шаардлагын нөхцөлийг уян хатан болгох
- Хөтөлбөрийн санхүүжилтийг 1-р улиралд багтаан шийдвэрлэж байх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нийцсэн сургалтын орчинг бүрдүүлэх
- Оролцогч нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулах арга зүй, ур чадвартай мэргэшсэн багш нарын тоог нэмэгдүүлэх
- Дүүрэг, хороодын ажлын уялдаа холбоог сайжруулан хамтын ажиллагааг сайжруулах
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зориулсан хөрөнгийг зорилтот бүлэгт нь ил тод чанартай хүргэхэд анхаарч тавих хяналтыг сайжруулах

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР